



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №14

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 11-р сарын 22 ноос 12-р сарын 25 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2023 оны 11-р сарын 22 ноос 12-р сарын 25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2, H3N8, H7N9, H5N1, H6N1, H10N8, H7N4, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна. Тухайн хугацаанд БНХАУ-ын Сычуань мужийн Бачжун хотод өндөр хоруу H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн. 2023 оны 10-р сарын 20 буюу шинж тэмдэг илрэхээс өмнө шувууны аж ахуйгаар орж байсан өгүүлэмжтэй. 2023 оны 10-р сарын 22 ноос эмчилгээг эхэлсэн боловч 11-р сарын 14 нд нас барсан. Өвчлөл бүртгэгдсэн тухайн улсын шувууны аж ахуй, худалдааны төвүүдээр зорчихгүй байх, зорчсон тохиолдолд амны хаалт зүүх, гараа угаах, ариутгах арга хэмжээг авах талаар зөвлөжээ.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2023 оны 11-р сарын 22 ноос 12-р сарын 25 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Австри, Белги, Болгари, Бразил, Камбоджи, Канад, БНХАУ, Колумби, Коста Рика, Хорват, Дани, Эквадор, Финланд, Франц, Герман, Хонг Конг, Унгар, Исланд, Израиль, Итали, Япон, Литва, Молдав, Нидерланд, БНСУ, Румын, Серби, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Тайвань, Их Британи зэрэг 35 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 415 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Европ, Төв Азийн улс оронд (Серби, Унгар, Итали, Словени) тогоруу, Зүүн Азийн улсад (БНСУ, Япон) өвөлжихөөр очсон галуу, нугасны төрлийн шувуудаас өвчлөл бүртгэгдсэн. Финланд улсад үнэг, булга зэрэг хөхтөн амьтны дунд өвчлөл бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Нугас, цацагт хяруул	31
H5N1	Австри	Тогоруу, Гунгар хун	6
H5N1	Белги	Тахианы аж ахуй, цууцал	3
H5N1	Болгари	Тахианы аж ахуй	4
H5N1	Бразил	Далайн арслан	1
H5N1	Камбоджи	Тахианы аж ахуй	4
H5N1	Канад	Алаг шунгаач, цацагт хяруул, тахианы аж ахуй	19
H5N1, H5N6,	БНХАУ	Тодорхойгүй	4

H9N2			
H5	Колумби	Тодорхойгүй	8
H5	Коста Рика	Тодорхойгүй	1
H5N1	Хорват	Тогоруу	1
H5N1	Дани	Шовтгор алаг нугас, бор галуу, эгэл шонхор, Branta leucopsis	8
H5N1	Эквадор	Тодорхойгүй	2
H5N1	Финланд	2 зүйл үнэг, булга	21
H5, H5N1	Франц	Мөнгөлөг цахлай, тогоруу	8
H5N1	Герман	Хун, нугас, тахиа, цацагт хяруулын аж ахуй	35
H5N1	Хонг Конг	Нугас, тандалтын сорьц материал	2
H5N1	Унгар	Галуу, нугас, шувууны аж ахуй	88
H5N5	Исланд	Хон хэрээ	1
H5N1	Израиль	Цацагт хяруул	3
H5N1	Итали	Цацагт хяруул, тогоруу	16
H5N1	Япон	Гангар хун, тогоруу, хэрээ	51
H5N1	Литва	Тодорхойгүй	1
H5N1	Молдав	Хун,	8
H5N1	Нидерланд	Галуу, Branta leucopsis, цахлай	21
H5N1	Польш	Галуу	4
H5N1	Португал	Цахлай	1
H5N3, H5, H5N6, H5N1	БНСУ	Гангар хун, зэрлэг нугас, шувууны аж ахуй	32
H5N1	Румын	Гунгар хун, шувууны аж ахуй	1
H5N1	Серби	Тогоруу	6
H5N1	Словени	Гунгар хун	1
H7N6, H5	Өмнөд Африк	Тодорхойгүй, тэмээн хяруул	7
H5N1	Испани	Chroicocephalus ridibundus, хүрэн толгойт цахлай, гунгар хун	4
H5N1	Швед	Branta leucopsis	5
H5N1	Тайвань	Тахианы аж ахуй	2
H5N1, H5N5	Их Британи	Тахианы аж ахуй, нугас, сар шувуу, харцага	5

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 2. 2023 оны 11-р сарын 22 ноос 12-р сарын 25 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

